



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/609

Булган сум

**Г Нийлүүлэгчид гэрээ байгуулах Г
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх нийлүүлэгчээр 1,2 дугаар багцад шалгарсан “Өвөлжөөнбулаг” ХХК-тай 1 дүгээр багцад Аймгийн нөөцөд өвс нийлүүлэх /90 000 000/ (ерэн сая) төгрөг, 2 дугаар багц Аймгийн нөөцөд тэжээл нийлүүлэх /60 000 000/ (жаран сая) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй ОНӨХХК (Б.Одхүү)-д олгосугай.

2. Гэрээнд заасан барааг холбогдох хууль, журам, стандартын дагуу бэлтгэн, тээврийн зардлыг бүрэн хариуцаж захиалагчийн заасан цэгт буулган хүлээлгэн өгч, гэрээний үүргийн биелэлтийг дүгнэн акт үйлдэхэд гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний чанарын баталгааг байршуулахыг “Өвөлжөөнбулаг” ХХК-ийн захирал (Б.Өлзийбаяр)-д үүрэг болгосугай.

3. Гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний чанарын баталгааг байршуулан, техникийн тодорхойлолтод заагдсан чанар стандарт, жин, хэмжээ, сав, баглаа боодол тоо ширхэгийн дагуу хүлээн авч хадгалалт, хувиарлалтад хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, Хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй ОНӨХХК (Б.Одхүү) нарт даалгасугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



46323020663

Аймгийн Засаг даргын 2023 оны
08 дугаар сарын 23-ны өдрийн
А/60 дугаар захирамжийн хавсралт



№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1.	Алданги	Хоногт тугуамд гэрээний үнийн дүнгийн 0,2 хувь байна.	Д.Батцогт
2.	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна.	Ч.Амгалан